



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/144

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-а, 29.2, 30.1.6, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4.1.1, 4.1.8, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 3.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Монгол цэргийн өдрийг угтан зохион байгуулах тэмцээн уралдааны тов гаргаж байгууллага, иргэдийг оролцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /дэд хурандаа Б.Ганхуяг/, Зэвсэгт хүчний 123 дугаар анги /хурандаа М.Болдбаатар/-д тус тус даалгасугай.


2. Монгол цэргийн өдрийг угтан явуулах Үндэсний бөхийн барилдаан, “Есөн Буянтай аав” шалгаруулалт, цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулах үйл ажиллагааны болон шагналд шаардагдах зардал 2.900.000 /Хоёр сая есөн зуун мянган/ төгрөгийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос, буудлагын болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд явуулах “Марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах” тэмцээний шагналд шаардагдах зардал 2.420.000 /хоёр сая дөрвөн зуун хорин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


D/Zax-A/144-Da

02 00683

3.Монгол цэргийн өдрийг угтан зохион байгуулах тэмцээн, уралдаанд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн
А/144 дүгээр захирамжийн хавсралт

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 98 ЖИЛИЙН ОЙ, МОНГОЛ ЦЭРГИЙН
ӨДРИЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДЛЫН ТООЦОО**

/Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос гарах/

д/д	Зохион байгуулах арга хэмжээний нэр	Тоо	Мөнгөн дүн	Бүгд
Нэг. Үндэсний бөхийн барилдаан				
1	Өргөмжлөл, дурсгалын зүйл		1000000	1000000
нийт дүн				1000000
Хоёр. "Буянтай аав" шалгаруулалт				
1	Өргөмжлөл, дурсгалын зүйл	9	100000	900000
Цэрэг спортын цогцолбор "Дөл" тэмцээн				
1	Тэргүүн байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	500000	500000
2	Дэд байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	300000	300000
3	Гутгаар байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	200000	200000
нийт дүн				1000000
Бүгд дүн				2.900.000

/Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гарах/

д/д	Зохион байгуулах арга хэмжээний нэр	Тоо	Мөнгөн дүн	Бүгд
Буудлагын тэмцээн				
1	Тэргүүн байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	50000	50000
2	Дэд байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	40000	40000
3	Гутгаар байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	30000	30000
нийт дүн				120000
Марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн				
1	Тэргүүн байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	1000000	1000000
2	Дэд байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	800000	800000
3	Гутгаар байр, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал	1	500000	500000
нийт дүн				2300000
Бүгд дүн				2.420.000

-оОо